



### САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Сэврэй сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ӨМА-2023/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Даланзадгад хот 2023 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: <a href="mailto:usukhbayarts@audit.gov.mn">usukhbayarts@audit.gov.mn</a> Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:Khongorzult@audit.gov.mn">Khongorzult@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Ж.Болормаа Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:Bolormaaja@audit.gov.mn">Bolormaaja@audit.gov.mn</a> Аудитор: Э.Жаргал Утас: 70533552 Цахим хаяг: <a href="mailto:jargale@audit.gov.mn">jargale@audit.gov.mn</a>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2023.03.24 № 276  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СЭВРЭЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА  
Б.БАТСАЙХАН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сэврэй сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэврэй сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Засаг даргын нөөц хөрөнгөөс журамд тусгагдаагүй арга хэмжээнд 12.5 сая төгрөг, анхан шатны бүрдэл дутуу баримтаар 15.3 сая төгрөг тус тус зарцуулсан, 2.1 сая төгрөгийн хүн амын орлогын албан татвар суутгаагүй нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн холбогдох заалтуудыг болон санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, эрх ба үүрэг, иж бүрэн байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд боловсролын байгууллагууд улсын төсөвт шилжсэнтэй холбоотойгоор үндсэн хөрөнгө 3,519.0 сая төгрөгөөр буурсан байна.

### Аудитын гол асуудлууд

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 7/04 дугаар тогтоолоор баталсан малын тоо, толгойн албан татварыг 35.9 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

016020375

### **Бусад асуудал**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,067,138.80	805,890.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	416,028.30	405,981.10
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	182,756.00	98,365.20
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	532.90	2,688.90
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	443,771.60	251,830.90
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	24,050.00	47,024.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		11,066,260.90	16,731,233.40
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	11,066,260.90	16,731,233.40
39200	Биет хөрөнгө		10,966,212.00	16,517,734.10
39300	Биет бус хөрөнгө	13	100,048.90	213,499.30
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		12,133,399.80	17,537,124.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		4,537,686.60	5,002,626.90
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	53,802.50	20,123.40
41300	Өглөг	17а, 17б	53,802.50	20,123.40
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		4,483,884.00	4,982,503.50
42200	Урт хугацаат зээл	20а, 20б	4,483,884.00	4,982,503.50
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		7,595,713.20	12,534,497.00
51	Засгийн газрын хувь оролцоо		7,595,713.20	12,534,497.00
51100	Засгийн газрын оруулсан капитал		3,626,499.10	2,153,813.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		3,626,499.10	2,153,813.00
51200	Хуримтлагдсан үр дүн		3,055,321.50	10,120,010.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		913,892.60	260,673.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		12,133,399.80	17,537,124.00

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		6,727,434.00	10,907,313.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО		137,971.60	229,157.40
110	Орлогын албан татвар		95,648.60	149,792.30
1100	Хувь хүний орлогын албан татвар		95,648.60	161,713.40
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-	-11,921.00
113	Хөрөнгийн албан татвар		31,938.90	58,076.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж		10,384.20	21,288.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	1,703,534.80	8,457,775.40
120	Нийтлэг татварын бус орлого		1,703,534.80	8,457,775.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		4,885,927.60	2,220,380.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	5,934,321.40	3,034,342.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ		5,934,321.40	3,034,342.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4,916,192.20	2,617,604.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,147,032.60	360,548.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		156,965.40	39,187.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		191,647.20	194,655.30
2104	Хангамж, бараа материалын зардал		142,939.50	100,138.10
2105	Нормативт зардал		200,176.40	4,512.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		35,497.40	78,921.50
2107	Томилот, зочны зардал		6,618.80	5,339.50

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		248,705.00	119,530.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,786,609.80	1,714,771.80
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,018,129.20	416,738.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		0	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		793,112.60	7,872,971.50
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		683,219.30	1,391.30
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		109,893.30	7,871,580.20

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,463,582.40	7,463,582.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	22,237.50	22,237.50
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,485,819.90	7,485,819.90
9	Тайлант үеийн үр дүн	109,893.30	109,893.30
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,595,713.20	7,595,713.20
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,595,713.20	7,595,713.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,932,796.40	-2,932,796.40
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,662,916.80	4,662,916.80
19	Тайлант үеийн үр дүн	7,871,580.20	7,871,580.20
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	12,534,497.00	12,534,497.00

### 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код:	Тайлангийн үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,647,078.90	3,048,887.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	137,971.60	229,157.40
110	Орлогын албан татвар	95,648.60	149,792.30
1100	Хувь хүний орлогын албан татвар	95,648.60	161,713.40
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-	(11,921.00)
113	Хөрөнгийн албан татвар	31,938.90	58,076.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	10,384.20	21,288.70
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	6,722.00	7,072.60
1181	Газрын төлбөр	3,662.20	12,353.70
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	-	1,862.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	665,387.30	599,348.80
120	Нийтлэг татварын бус орлого	665,387.30	599,348.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,843,720.00	2,220,380.80
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,312,323.30	2,863,047.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,312,323.30	2,863,047.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,294,194.00	2,446,209.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,209,169.30	411,654.80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	171,160.40	69,978.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	211,072.30	225,738.40
2104	Хангамж, бараа материалын зардал	272,913.00	237,767.60
2105	Нормативт зардал	93,808.30	5,112.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,687.00	66,443.10
2107	Томилолт, зочны зардал	6,618.80	4,874.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	109,028.60	114,968.40
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,195,736.40	1,309,671.60

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,018,129.20	416,838.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	334,755.60	185,839.70
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	173,299.00	195,886.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	173,299.00	195,886.90
2200	Дотоод эх үүсвэрээр	173,299.00	195,886.90
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(173,299.00)	(195,886.90)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	161,456.60	(10,047.20)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	254,571.60	416,028.30
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	416,028.30	405,981.10

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,636,168.20	1,378,073.90	801,442.65	576,631.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,636,168.20	1,378,073.90	801,442.65	576,631.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,058,831.30	789,538.64	789,438.64	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	289,441.30	276,626.32	276,626.32	-
210101	Үндсэн цалин	215,366.10	213,251.60	213,251.60	-
210102	Нэмэгдэл	55,827.50	45,389.63	45,389.63	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	-	-	-
210104	Урамшуулал	18,247.70	17,985.10	17,985.10	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,606.90	34,200.98	34,200.98	-
210201	Тэтгэврийн даатгал	27,228.00	23,548.94	23,548.94	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,786.50	2,665.25	2,665.25	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,334.10	2,216.94	2,216.94	-
210204	Ажилгүйдлийн даатгал	568.80	531.24	531.24	-
210205	Эрүүл мэндийн даатгал	5,689.50	5,238.61	5,238.61	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	327,116.60	319,832.58	319,832.58	-
210301	Гэрэл, цахилгаан	20,707.50	17,716.34	17,716.34	-
210302	Түлш, халаалт	278,921.90	279,098.58	279,098.58	-
210303	Цэвэр, бохир ус	27,487.20	23,017.65	23,017.65	-
2104	Хангамж, бараа материалын зардал	82,185.60	68,060.92	68,060.92	-
210401	Бичиг хэрэг	8,535.30	6,142.05	6,142.05	-
210402	Тээвэр, шатахуун	53,725.00	46,599.56	46,599.56	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,312.00	9,306.61	9,306.61	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,300.00	1,094.00	1,094.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,313.30	4,918.70	4,918.70	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,821.70	8,221.10	8,221.10	-
210604	Урсгал засвар	11,821.70	8,221.10	8,221.10	-
2107	Томилолт, зочны зардал	7,080.00	6,264.00	6,264.00	-
210702	Дотоод албан томилолт	7,080.00	6,264.00	6,264.00	-
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	-	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,847.10	73,063.54	73,063.54	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	81,847.10	73,063.54	73,063.54	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	220,732.10	3,269.20	3,169.20	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	216,010.90	100.00	100.00	-

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,721.20	3,169.20	3,169.20	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,577,336.90	588,535.27	12,004.01	576,531.25
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	1,552,836.90	576,531.25	-	576,531.25
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	1,552,836.90	576,531.25	576,531.25	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	24,500.00	12,004.01	12,004.01	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	24,500.00	12,004.01	12,004.01	-
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	2,636,168.20	1,702,402.99	834,125.62	858,136.83
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	882,696.50	810,238.82	72,457.68
310001	Улсын төсвөөс санхүүжих	-	-	867,238.82	(867,238.82)
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	-	882,696.50	-	882,696.50
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,847,516.90	777,555.85	-	780,916.81
320001	Орон нутгийн төсвөөс	964,820.40	777,555.85	-	780,916.81
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	882,696.50	-	882,696.50	(882,696.50)
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	788,651.30	42,150.65	23,886.80	4,762.35
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	111,000.00	42,150.65	42,150.65	(13,501.50)
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	677,651.30	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	726,908.23	-	729,785.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,051,237.32	-	1,051,237.32
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>90</b>	<b>90</b>	<b>0</b>	<b>90</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>8</b>	<b>8</b>	<b>0</b>	<b>8</b>
610001	Төсвийн байгууллага	8	8	0	8
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>41</b>	<b>41</b>	<b>0</b>	<b>41</b>
620001	Удирдах ажилтан	7	7	0	7
620002	Гүйцэтгэх ажилтан	13	13	0	13
620003	Үйлчлэх ажилтан	21	21	0	21
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>41</b>	<b>41</b>	<b>0</b>	<b>41</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	14	14	0	14
650009	Төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮ)	21	21	0	21
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6	6	0	6

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан мянган төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ТАЙЛАНТ ОН
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,107,154.56
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,107,154.56
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,098,295.70
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	5,403.75
210101	Үндсэн цалин	5,403.75
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	675.47
210201	Тэтгэврийн даатгал	675.47
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,470.97
210401	Бичиг хэрэг	1,100.00
210402	Тээвэр, шатахуун	4,350.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,512.00
210502	Хоол, хүнс	4,512.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,499.50

210604	Урсгал засвар	1,499.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,080,734.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,080,734.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	8,858.86
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	7,742.09
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,742.09
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	1,116.78
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,116.78
<b>I</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,107,074.84
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,107,074.84
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,093,825.76
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,903.37
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,345.71
<b>III</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	(79.72)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	79.72
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 768.4 сая төгрөгийн 14 алдаа, зөрчил илэрснээс, 1.7 сая төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 728.0 сая төгрөгийн 8 зөрчилд 2 албан шаардлага, 2.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 32.4 сая төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгч ажиллаа.

Шилэн дансны тухай хууль хэрэгжилтийг шалгах явцад илэрсэн зөрчлийг аудитын дүгнэлтэд хамааруулахгүй бөгөөд залруулагдаагүй зөрчлийн дүн нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 21.2 сая төгрөгт хүрсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт өглөө.

Аудитаар нийт 1.7 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 1.7 сая төгрөгийн алдааг залруулж ажиллалаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлан дахь худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 0.02 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг бараа материалын тодруулга тайлангийн тусламж хандиваар авсан нийт дүнтэй тулган баталгаажуулахад 0.002 сая төгрөгийн дутуу тайлагнасан
- Санхүү үр дүнгийн нэг удаагийн тэтгэмж,урамшууллын зардлыг мөнгөн гүйлгээний тайлан дахь уг зардалтай тулган баталгаажуулахад 1.5 сая төгрөгөөр дутуу тайлагнасан

Аудитаар нийт 766.5 сая төгрөгийн 11 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 2.1 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 728.0 сая төгрөгийн 10 зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 32.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- Тайлант онд Засаг даргын нөөц сангаас 21.3 сая төгрөгийг зарцуулалт хийхдээ 2.1 сая төгрөгийн татвар тооцоогүй олгосон байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.4"энэ хуулийн 15.1, 16 дугаар зүйл, 17.1.2, 17.1.3-т зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар"- гэж заасантай нийцэхгүй байна.

## 5.2 Албан шаардлага

- Тайлант хугацаанд нөөц сангийн хөрөнгөөс 10.0 сая төгрөгийн суурин болон зөөврийн компьютер худалдан авсан,
- Засаг даргын нөөц сангаас Цагдаагийн албан хаагчийн байрны урсгал засварын зардал 8.0 сая төгрөгийг капиталжуулж бүртгэлд тусгаагүй,
- Засаг даргын нөөц сангаас Ерөнхий боловсролын сургууль болон Соёлын төвд жил бүр зохион байгуулдаг хэвийн үйл ажиллагааг хангахад 2.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Засаг даргын нөөц сангаас зарцуулалт хийхдээ зөвлөлийн хурлаар хэлцээгүй, гүйцэтгэлийн ажлын тайлан гаргуулан аваагүй,
- Засаг даргын нөөц сангаас 15.4 сая төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*", Нягтлан бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1"*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*",13.7 "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-д заасантай тус тус нийцэхгүй байна.

## 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **Төсвийн бүрдүүлэлттэй холбоотой асуудал**

**Илрүүлэлт 1:** Тайлант онд бууны албан татвар 0.5 сая төгрөгөөр төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1"*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*", Галт зэвсгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 "*өөрийн өмчлөлд байгаа галт зэвсгийг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор цагдаагийн байгууллагад бүртгүүлж албан татварыг тогтоосон хугацаанд төлөх, эвдэрч ашиглагдахгүй болсон галт зэвсгийг зохих журмын дагуу бүртгэлээс хасуулах*", 7 зүйлийн 7.1"*Албан татвар төлөгч албан татварыг жил бүрийн 12 дугаар сарын 01-ний дотор орон нутгийн төсөвт төлнө*", Баян-овоо сумын ИТХ-н 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 7/2 тоот тогтоолын 1 дүгээр зүйлд заасантай тус тус нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж албан татварыг төсөвт бүрэн төвлөрүүлэх,

**Илрүүлэлт 2:** Малын тоо, толгойн албан татвар 35.9 сая төгрөгөөр төсөвт дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "*хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх*", Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1"*Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малыг өмчилж буй малчин, мал бүхий этгээд нь албан татвар төлөгч байна*",7 дугаар зүйлийн 7.1"*Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө*"-гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж албан татварыг төсөвт бүрэн төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газарт 2023 оны 10 дугаар сарын 13 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Алдаа зөрчлийн утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг үндсэн хөрөнгийн тодруулга тайлан дахь худалдан авсан хөрөнгийн дүнтэй тулган баталгаажуулахад 200,000 төгрөгөөр дутуу тайлагнасан	1	0.20	-	-	1	0.20	1	0.2	-	-	-	-
Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг бараа материалын тодруулга тайлангийн тусламж хандиваар авсан нийт дүнтэй тулган баталгаажуулахад 20,000 төгрөгийн дутуу тайлагнасан	1	0.02	-	-	1	0.02	1	0.0	-	-	-	-
Санхүү үр дүнгийн нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг мөнгөн гүйлгээний тайлан дахь уг зардалтай тулган баталгаажуулахад 1,567,000 төгрөгөөр дутуу тайлагнасан	1	1.57	-	-	1	1.57	1	1.6	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>1.79</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>1.79</b>	<b>3</b>	<b>1.79</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл асуудал

/сая төгрөгөөр/

Алдаа зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
нөөц сангийн хөрөнгөөс 10,000,000 төгрөгийн суурин болон зөөврийн компьютер худалдан авсан	1	10.00			1	10.00							
нөөц сангийн хөрөнгөөс Цагдаагийн албан хаагчийн байрны урсгал засварын зардал 8,000,000 төгрөгийг капиталжуулж бүртгэлд тусгаагүй	1	8.00				8.00							
Засаг даргын нөөц сангаас Ерөнхий боловсролын сургууль болон Соёлын төвд жил бүр зохион байгуулдаг хэвийн үйл ажиллагааг хангахад 2,561,250 төгрөгийн дэмжлэг үзүүлэн төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	1	2.56				2.56							

Засаг даргын нөөц сангаас зарцуулалт хийхдээ зөвлөлийн хурлаар хэлцээгүй, гүйцэтгэлийн ажлын тайлан гаргуулан аваагүй байна.	1	-				-						
Засаг даргын нөөц сангаас 15,393,000 төгрөгийг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй зарцуулсан	1	15.39				15.39						
Тайлант онд Засаг даргын нөөц сангаас 21,306,540 төгрөгийг зарцуулалт хийхдээ 2,130,654 төгрөгийн татвар тооцоогүй олгосон	1	2.13	1	2.13								
Тайлант онд бууны албан татвар 500,000 төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.	1	0.50					1	0.50				
Тайлант онд малын тоо, толгойн албан татвар 35,942,840 төгрөгийг дутуу төвлөрүүлсэн	1	35.94					1	35.94				
<b>Дүн</b>	<b>8</b>	<b>74.53</b>	<b>1</b>	<b>2.13</b>	<b>1</b>	<b>35.95</b>	<b>2</b>	<b>36.44</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

Алдаа зөрчлийн утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд 21 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан	1	86.31			1	86.31		
28,485,300 төгрөгийн 3 шийдвэрийн мэдээллийг байршуулаагүй	1	28.49				28.49		
5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий санхүүжилтийн 15 гүйлгээ буюу 539,290,888.68, гүйцэтгэлийн 4 гүйлгээ буюу 37,969,949 төгрөгийг мэдээлээгүй	1	577.26				577.26		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>692.06</b>				<b>692.06</b>		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>692.06</b>			<b>1</b>	<b>692.06</b>		